

МОНГОЛ ХЭЛ

2009

ХУВИЛБАР А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Алчуур боосон хуур

Эмээ бурхан боллоо	Харууслын сүүдэр унагахгүй гэж манай говийнхон
Налж суудаг уул минь нурж	Дор хаяад
Намрын нуур ангираа гүвлээ	Долоон долоон дөчин есөн хоног боодог
Эмээ бурхан боллоо	Хорвоогийн гашууныг амсаа нь үгүй
Буурал бүүвэйн эгшиг тасарч	Хонгор гэнэн аашиндаа согтож
Буруу хатавчинд өрхний оосор ээдрэв	Хоймроо асан тонгочиж байгаад
Эгшгийн гэгээ татах хуурын	Хоног хураах яагаа ч үгүй байхад
Эрдэнийн ногоон халзан морины толгойг	Хуурын боолтыг унагахад нь
Эгчийн алчуураар боолоо	Ногоон халзан морины цагаан хөлхтэй зовхи
Тэвхэн дээгүүр урсах хос мөрөн утсан дээгүүр	Нойтон байж билээ
Тэнгэрийн заадсаар хиллэн татахад	Шүүрс алдам энэ дурдатгалын хуруудыг мэрэхэд
Халуун шаргал аялгуу асгах хуурын нүдэнд	Шүд заншил хоёр эмтрэх шиг болдгийм

(Б.Лхагвасүрэн)

- Эхийн эхлэл, гол, төгсгөлийн тулгуур өгүүлбэр бүхий хэсгийг олоорой.
 - Эмээ бурхан боллоо.
Хуурын боолтыг унагахад ... нойтон байж билээ
Шүд заншил хоёр эмтрэх шиг болдгийм
 - Намрын нуур ангираа гүвлээ
Долоон долоо дөчин есөн хоног боодог
Шүд заншил хоёр эмтрэх шиг болдгийм
 - Налж суудаг уул минь нурж ...
Тэнгэрийн заадсаар хиллэн татахад ...
Шүүрс алдам энэ дурдатгалын хуруудыг мэрэхэд ...
 - Эмээ бурхан боллоо
Халуун шаргал аялгуу асгах хуурын нүдэнд ...
Нойтон байж билээ
 - Буруу хатавчинд өрхний оосор ээдрэв
Хоймроо асан тонгочиж байгаад ...
Шүд заншил хоёр эмтрэх шиг болдгийм
- Эхийн төрсөн санааг илэрхийлсэн тулгуур үгсийг олоорой.
 - Ангир, өрх, хоног
 - В. Эгшиг, оосор, аялгуу
 - С. Эмээ, хуур, заншил
 - Д. Эмээ, өрх, шүд
 - Е. Нуур, ангир, дурдатгал
- Эхийн гол санааг тодорхойлоорой.
 - А. Амьтай бүхэн бөхдөг хорвоогийн жамыг харуулсан
 - В. Хүний амьдралд жаргал зовлон ээлжилдэг
 - С. Хүүхэд гэдэг ариухан цагаан сэтгэлтэй байдаг гэдгийг харуулсан
 - Д. Амьдралынхаа зураг төөргийг хүн өөрөө л бүтээдэг
 - Е. Өвөг дээдэстэй минь хамт ёс заншил үгүй болж байна
- Шинэ санааг илэрхийлсэн дүрслэх ур маягийг тодорхойлоорой
“Ногоон халзан морины цагаан хөлхтэй зовхи
Нойтон байж билээ”
 - А. Тойруулал
 - В. Төлөөлөл
 - С. Хэтрүүлэл
 - Д. Зүйрлэл
 - Е. Адилтгал
- Зохиогчийн харуусан гэмшсэн үнэлэмжийг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
 - А. Буурал бүүвэйн эгшиг тасарч
Буруу хатавчинд өрхний оосор ээдрэв
 - В. Шүүрс алдам энэ дурдатгалын хуруудыг мэрэхэд
Шүд заншил хоёр эмтрэх шиг болдгийм
 - С. Дор хаяад
Долоон долоо дөчин есөн хоног боодог

- D. Эрдэнийн ногоон халзан морины толгойг
Эгчийн алчуураар боолоо
E. Налж суудаг уул минь нурж
Намрын нуур ангираа гүвлээ
6. Дээрх эхийн сэдвийг тодорхойлоорой.
A. Эх үрийн элбэрэл хайрын тухай
B. Намрын тухай
C. Хүний хувь заяаны тухай
D. Монгол ёс заншлын тухай
E. Гэнэн хонгор хүүгийн тухай
7. Эхийн хэв маягийг олоорой.
A. Хүүрнэмж
B. Тайлбарламж
C. Эргэцүүлэмж
D. Тоочимж
E. Учирламж
8. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
Эхийн сэдвийг үйл явдлаар дүрсэлж, дүгнэлт гаргахыг гэнэ.
A. Төрсөн санаа
B. Гол санаа
C. Шинэ санаа
D. Зорьсон санаа
E. Төгс санаа
9. Эхийг уншаад “эмээ”-г тодотгон адилтгасан дүрслэл бүхий хэсгийг олоорой.
A. Ангир, эгшиг, оосор
B. Уул, ангир, эгшиг
C. Уул, нуур, эгшиг
D. Бүүвэй, хатавч, өрх
E. Бүүвэй, эгшиг, оосор
10. Дараах өгүүлбэрийн утгын харьцааг тодорхойлоорой.
“Эмээ бурхан боллоо.
Налж суудаг уул минь нурж
Намрын нуур ангираа гүвлээ”
A. Зүйлчилсэн
B. Төсөөт
C. Эсрэг
D. Ойролцоо
E. Ижил
11. Дараах өгүүлбэрийн баймж утгыг тодорхойлоорой.
“Шүд заншил хоёр эмтрэх шиг болдгийм”
A. Зайлшгүй баймж
B. Бодит баймж
C. Боллоцот баймж
D. Хэм хэмжээт баймж
E. Таамагласан баймж
12. Дараах өгүүлбэрийн шинжид тохирох тодорхойлолтыг олоорой.
“Намрын нуур ангираа гүвлээ”
A. Энгийн, хүүрнэх, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
B. Энгийн, хүүрнэх, гурван бүрэлдэхүүнт, цөм бус өгүүлбэр
C. Энгийн, хүүрнэх, хоёр бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
D. Энгийн, хүүрнэх, хоёр бүрэлдэхүүнт, цөм бус өгүүлбэр
E. Энгийн, захирах, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
13. Дараах өгүүлбэрийн бүтцийг тодорхойлоорой.
“...Хуурын боолтыг унагахад нь
Ногоон халзан морины цагаан хөлхтэй зовхи
Нойтон байж билээ”
A. Цагийн байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
B. Орны байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
C. Болзлын байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
D. Шалтгааны байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
E. Өгүүлэгдэхүүн гишүүн өгүүлбэртэй харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
14. Утгазүйжсэн холбоо үг бүхий хэсгийг олоорой.
A. Ангираа гүвэх, буурал бүүвэй, эгчийн алчуур
B. Хуурын боолт, буурал бүүвэй, хөлхтэй зовхи
C. Энэ дурдатгал, өрхний оосор, манай говийнхон
D. Тэвхэн дээгүүр, тонгочиж бай-, эмтрэх шиг
E. Бурхан бол-, хоног хураа-, заншил эмтэр-
15. Дараах өгүүлбэрийн онцолсон үг ямар гишүүн болох вэ?
“Хоймроо асан тонгочиж байгаад...”
A. Өгүүлэгдэхүүн
B. Өгүүлэхүүн
C. Байц
D. Шууд тусагдахуун
E. Шууд бус тусагдахуун
16. Эхэд орсон дараах өгүүлбэр ямар хувиргалаар илэрснийг тодорхойлоорой.
“Эмээ бурхан боллоо
Буурал бүүвэйн эгшиг тасарч
Буруу хатавчинд өрхний оосор ээдрэв”
A. Хураах
B. Салаалах
C. Дэлгэрүүлэх
D. Тонгоргох
E. Ижилсүүлэх

17. Цэгийн оронд тохирох үгийг зөв дарааллаар байрлуулсан хэсгийг олоорой.
“...Эр зүрхний тэнгэр
Их санахын тэнгэр
Илч гэрлийн тэнгэр
Ижий галын тэнгэр хань минь” /Б.Лхагвасүрэн /
А. Ач, оч, ад, од В. Оч, од, ач, ад С. Ад, ач, од, оч
D. Од, ад, оч, ач E. Од, оч, ад, ач
18. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
А. Ургамлын сайхан нь цэцэгсийн дотор байх гэлцэнэ.
В. Сэтгэл гэдэг бол хүний биед хоргодох нөмөр олсон бурхан юм.
С. Хүн бол урмаар ургадаг ургамал.
D. Орчлонгийн зулай бол уулс юм.
E. Цаасан дээр мөртэй, цасан дээр нэртэй явсан хүн шүү, би.
19. Онцолсон хэлц өгүүлбэрийг утгаар нь солин найруулбал аль нь тохирох вэ?
“Шүүрс алдам энэ дурдатгалын хуруудыг мэрэхэд... ”
А. Санаа алдам В. Сэтгэл алдам С. Нүд алдам
D. Зүрх алдам E. Хөл алдам
20. Дараах үгсийн аймгийг жишээтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
1. Буурал, гэнэн, халуун, нойтон А. Төлөөлөх үгс
2. Харуусал, тэвх, хурууд В. Тооны нэр
3. Долоон долоо, хоёр, дөчин ес С. Жинхэнэ нэр
4. Энэ, яагаа ч, миний D. Тэмдэг нэр
А. 1A, 2B, 3C, 4E В. 1C, 2B, 3A, 4D С. 1B, 2A, 3C, 4D
D. 1C, 2A, 3B, 4D E. 1D, 2C, 3B, 4A
21. Дараах хэлзүйн тайлбарт тохирох үгийг олоорой.
/Ерийн, үүсмэл, ганц тоот, харьяалахын тийн ялгалд байгаа жинхэнэ нэр/
А. Морины В. Дурдатгалын С. Эрдэнийн
D. Хорвоогийн E. Хуурын
22. Дараах үгсийн утга, бүтцийг ажиглаад, бусдаасаа өвөрмөц үгийг олоорой.
А. Нуран В. Согтон С. Тэвхэн
D. Асан E. Татан
23. Харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утгыг жишээтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
1. Эзний А. Морины толгой
2. Зориулалтын В. Намрын нуур
3. Бүхэл хэсгийн С. Эгчийн алчуур
4. Цаг хугацааны D. Хуурын боолт
А. 1D, 2C, 3A, 4B В. 1B, 2C, 3A, 4D С. 1A, 2B, 3C, 4D
D. 1C, 2D, 3A, 4B E. 1B, 2A, 3D, 4C
24. Дараах холбоо үгсийг ажиглаад, үндсэн (шууд) утгаараа байгаа үгийг олоорой.
А. Ханьн толгой В. Шүдэнзний толгой С. Сонины толгой
D. Морины толгой E. Цагаан толгой
25. Дараах үгсэд бүгдэд нь тохирох дүрмийг тодорхойлоорой.
“Харуусал + ын, хоймор + оо, намар + ын ”
А. Эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад төгсгөлийн балархай эгшиг гээгдэнэ
В. Эгшигт гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч эгшиггүй бичигдэнэ
С. Эгшигт гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл гээхгүй
D. Дараалсан хоёр заримдаг гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл эгшгийг гээхгүй
E. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад төгсгөлийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэнэ
26. Дараах үгсээс төрөл биш үгийг олоорой.
А. Шаргал В. Шарга С. Шарагчин
D. Шарва E. Шарла
27. Дараах үгсээс хуучирсан үг бүхий хэсгийг олоорой.
А. Аниа, ажаа, амбаа В. Занги, амбан, жасаа
С. Тунхуу, бураа, хараач D. Хөлийн цэц, тамгын газар, хоршоо
E. Ноёд, хатагтай, айлтгал
28. Дараах үгсийг утгатай нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
1. Онхол, цонхол, мэлрэх, элмэрэх А. Ойролцоо утгат үг

2. Суу, билэг, авьяас, мэдрэмж В. Төсөө утгат үг
3. Газар, тэнгэр, гал, ус С. Эсрэг утгат үг
4. Айлчин, гийчин, зочин, D. Зүйлчилсэн утгат үг
 A. 1A, 2B, 3C, 4D В. 1D, 2C, 3B, 4A C. 1D, 2A, 3C, 4B
 D. 1C, 2A, 3B, 4D E. 1B, 2D, 3C, 4A
29. Дараах үгсээс нэр язгуур бүхий хэсгийг олоорой.
 A. Цөмлөх, нэвтрэх, задрах, бяцлах В. Тарих, давтах, хөдөлмөрлөх, үйлдэх
 C. Суллах, нүдлэх, ганзагалах, хайрлах D. Хоржигнох, ганганах, тогших, цангинах
 E. Жингэнэх, годгонох, хурхирах, сандрах
30. Дараах үгийг бүтцээр зөв задалсныг олоорой.
 A. Ангир + 0+0 + аа В. Ангир + 0 + аа C.Анги + р + аа
 D. Ангир + аа E. Ангир + аа + 0
31. Дараах агуулгын тайлбараас бурууг нь олоорой.
 A. “Тээрэмчин” туужид дэлхийн хоёрдугаар дайны он жилүүдэд эр хүн бие амсхийж, агт морь хөл амрах зав байсангүйг эр хүний зориг тэсвэр, ажил үйлстэй нягт холбон үзүүлжээ.
 B. “Үер” туужид ядуу ардын гологдсон хүүхэн ардын хувьсгалын ач, төр засгийн ивээлээр эрх чөлөөгөө олж, эрдэм номтой боловсон хүчин болсныг үзүүлжээ.
 C. “Халуун амьсгал” тууж нь монгол хүний харилцан нэгнээ халамжлан түшдэг хүнлэг зан заншил үгүй болж, бие биедээ санаа тавих, ажил амьдралд нь туслах нь бага болсон тухай үзүүлжээ.
 D. “Их тээлийн даваа” туужид дөрвөн цагийн эргэлтэд малчин хүний амьдралын эрээн барааныг дүрслэн үзүүлжээ.
 E. “Залуу хос” туужид хувьсгалаар өөрчлөгдөн шинэчлэгдсэн шинэ ахуй нөхцөл, соёлтой боловсролтой шинэ хүн төрж өссөн явцыг хайр сэтгэлийн өгүүлэмжээр амьдрал тэмцлийн талбарт бодитой дүрсэлжээ.
32. Зохиолч ба зохиолын нэрийг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
 1. Ц.Гайтав А. Хурандаа
 2. Д.Пүрэвдорж В. Үр могой
 3. Ч.Лхамсүрэн С. Багш
 4. Ш.Сүрэнжав D. Ширмэн цөгцний дууль
 5. Б.Лхагвасүрэн E. Дамдины Сүхбаатар
 A. 1A, 2B, 3C, 4D, 5E В. 1E, 2D, 3A, 4C, 5B C. 1D, 2C, 3E, 4B, 5A
 D. 1B, 2A, 3E, 4D, 5C E. 1D, 2E, 3A, 4B, 5C
33. Дараах шүлгийн цэгийн оронд доорх өгөгдлөөс зөвийг сонгоно уу.
 “Мөрөн голын усыг эзэгнэнхэн төрлөө, би
 Мөнгөн сарны сүүдэр толиорон хөвөх долгионд
 Миний өвөг дээдсийн морин туурайд наалдсан

 Мөрөн голын усыг эзэгнэнхэн төрлөө, би”
 A. Зуун түмэн үед монгол хүний идээшсэн
 B. Үлэг гүрвэлийн мөрийг өдий хүртэл хадгалсан
 C. Хөрст алтан дэлхийн үрчлээт магнай болсон
 D. Хүний нутгийн шороог ариун усаараа угаасан
 E. Үрэл усан шүүдэрт нь одод гялалзах дэлбээнд
34. Зүй тогтлыг ажиглаад цэгийн оронд тохирохыг олоорой.
 “Халуун амьсгал”, ”Чөтгөр”, “Учиртай гурван толгой”, “Үер”
 A. Ану хатан В. Яг арван найм C. Залуу нас
 D. Тээрэмчин E. Их хувь заяа
35. Д.Нацагдоржийн “Ламбагуайн нулимс” өгүүллэгийн Цэрэнлхам, Лодон гэвш нарын дүрийг уран сайхны ямар аргаар дүрсэлсэн бэ?
 “Винайн ёсыг сахисан - уран тачаангуйн хурц илдийг боловсруулсан, улаан шарыг тунуулсаар - цагаан харыг гялбалзуулсаар”
 A. Хураангуйлал В. Сөөлжүүлэл C. Харшуулал
 D. Бууруулал E. Ахиулал
36. Цэгийн оронд уран зохиолын төрөл зүйлүүдээс тохирохыг олоорой.
 “Хүний сэтгэлийн догдлол, амьдралын содон мөчлөг, байгалийн үзэгдэл байдал зэрэг онцгой гол явдлыг тодруулан дүрсэлсэн, хэмжээгээрээ өгүүллэгээс их, романаас багавтар зохиолыг гэнэ”
 A. Тууж В. Найраглал C. Роман
 D. Өгүүллэг E. Жүжиг

37. Үйлийн эс хувилгагч нөхцөлтэй үгс бүхий хэсгийг олоорой.

- A. B. C. D. E.

38. Дан зөөлөн дэвсгэрээр төгссөн үгтэй хэсгийг олоорой.

- A. B. C. D. E.

39. Дараах өгүүлбэрийн тодруулсан үгийг монгол бичгээр зөв бичсэнийг олоорой.

“Үрэл усан шүүдэрт нь одод гялалзах дэлбээнд...”

- A. B. C. D. E.

40. Дараах үгсийг утгатай нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1. 2. 3. 4. 5.

a. Бяслаг шах-

b. Бага сага

c. Шагайж хар-

d. Шагай нясал-

e. Шатрын шаг

A. 1d, 2c, 3e, 4b, 5a

B. 1c, 2b, 3a, 4d, 5e

C. 1d, 2b, 3e, 4c, 5a

D. 1e, 2c, 3d, 4b, 5a

E. 1e, 2d, 3a, 4c, 5b

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Зохиолын нэр ба ишлэлийг зөв харгалзуулаарай.

- | | |
|--|--|
| 1. Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний цэцэлсэн шастир | A. "...Алд бие минь алжааваас алжаатугай Аху төр минь бүү алдартугай..." |
| 2. Чингисийн эр хоёр загалын тууж | B. "...Бор зүрх минь бол бол хийв. Богино хавирга минь шир шир хийв..." |
| 3. Чингисийн билиг | C. "...Харцага шувууг гэжээж харугана шувуунд тавибал Харин дээш хальж хацар зулайд халдах ажгуу..." |
| 4. Гурван зуун тайчуудыг дарсан домог | D. "...Ачит эзэндээ захирагдахад хүрвээс Арга доор нь дагалдаж яв..." |
| 5. Алтан ордны үйсэн дээрх бичиг | E. "...Сайн моринд эзэн олон биш үү Өнөр хүнд нөхөр олон биш үү..." |

2.2. Хэлцүүдийг эсрэг утгаар нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------------|----------------------|
| 1. Зүрх нь үх- | A. Ааг нь буцал- |
| 2. Хулхи нь буу- | B. Хөрөнгөндөө сага- |
| 3. Хөг нь өнгөр- | C. Ааг нь эрчил- |
| 4. Хоног төөрүүл- | D. Чихний чимэг бол- |
| 5. Чихний чийр бол- | E. Зориг нь бадар- |

2.3. Хэлц холбоо үгийн хэв шинжийг тохирох үгтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|----------|---------------------------------|
| 1. ХЗ+ХЗ | A. Хэвлэгдэж байгаа сурах бичиг |
| 2. ХЗ+ҮС | B. Тэр өдрийн баяр хөөр |
| 3. УЗ+ХЗ | C. Үнэний тухай мэдэж байх |
| 4. БЗ+ҮС | D. Айлын зайд толгой хоргодох |
| 5. УЗ+УЗ | E. Аяга ёроолдон сууж байх |

2.4. Найруулгын төрлийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------------------------|--|
| 1. Албан бичгийн найруулга | A. Үлгэн салган биетэй
Үнэгэн сүүлэн малгайтай |
| 2. Эрдэм шинжилгээний найруулга | B. Аргентины шинжээчид үлэг гүрвэлийн одоо болтол
мэдэгдээгүй байгаа нэгэн төрлийг илрүүлэв |
| 3. Сонин нийтлэлийн найруулга | C. Та байна аа, нисэхэд суугаад номын сан дээр бууна. За юу |
| 4. Уран зохиолын найруулга | D. Химийн шинжилгээний дүнгээс үзэхэд, дэрс толгойлох
үедээ 10-13% протейн, 34-45% ислэгтэй байна |
| 5. Ярианы найруулга | E. 5-р зүйл. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим |

ХУВИЛБАР G

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Алчуур боосон хуур

Эмээ бурхан боллоо	Харууслын сүүдэр унагахгүй гэж манай говийнхон
Налж суудаг уул минь нурж	Дор хаяад
Намрын нуур ангираа гүвлээ	Долоон долоон дөчин есөн хоног боодог
Эмээ бурхан боллоо	Хорвоогийн гашууныг амсаа нь үгүй
Буурал бүүвэйн эгшиг тасарч	Хонгор гэнэн аашиндаа согтож
Буруу хатавчинд өрхний оосор ээдрэв	Хоймроо асан тонгочиж байгаад
Эгшгийн гэгээ татах хуурын	Хоног хураах яагаа ч үгүй байхад
Эрдэнийн ногоон халзан морины толгойг	Хуурын боолтыг унагахад нь
Эгчийн алчуураар боолоо	Ногоон халзан морины цагаан хөлхтэй зовхи
Тэвхэн дээгүүр урсах хос мөрөн утсан дээгүүр	Нойтон байж билээ
Тэнгэрийн заадсаар хиллэн татахад	Шүүрс алдам энэ дурдатгалын хуруудыг мэрэхэд
Халуун шаргал аялгуу асгах хуурын нүдэнд	Шүд заншил хоёр эмтрэх шиг болдгийм

(Б.Лхагвасүрэн)

- Эхийн эхлэл, гол, төгсгөлийн тулгуур өгүүлбэр бүхий хэсгийг олоорой.
 - Буруу хатавчинд өрхний оосор ээдрэв
Хоймроо асан тонгочиж байгаад ...
Шүд заншил хоёр эмтрэх шиг болдгийм
 - Намрын нуур ангираа гүвлээ
Долоон долоо дөчин есөн хоног боодог
Шүд заншил хоёр эмтрэх шиг болдгийм
 - Налж суудаг уул минь нурж ...
Тэнгэрийн заадсаар хиллэн татахад ...
Шүүрс алдам энэ дурдатгалын хуруудыг мэрэхэд ...
 - Эмээ бурхан боллоо
Халуун шаргал аялгуу асгах хуурын нүдэнд ...
Нойтон байж билээ
 - Эмээ бурхан боллоо
Хуурын боолтыг унагахад ... нойтон байж билээ
Шүд заншил хоёр эмтрэх шиг болдгийм
- Эхийн төрсөн санааг илэрхийлсэн тулгуур үгсийг олоорой.

A. Ангир, өрх, хоног	B. Оосор, гэгээ, аялгуу	C. Эмээ, хуур, заншил
D. Эмээ, өрх, шүд	E. Нуур, ангир, дурдатгал	
- Эхийн гол санааг тодорхойлоорой.
 - Амьтай бүхэн бөхдөг хорвоогийн жамыг харуулсан
 - Хүний амьдралд жаргал зовлон ээлжилдэг
 - Хүүхэд гэдэг ариухан цагаан сэтгэлтэй байдгийг харуулсан
 - Амьдралынхаа зураг төөргийг хүн өөрөө л бүтээдэг
 - Миний өвөг дээдэстэй хамт ёс заншил минь үгүй боллоо

4. Шинэ санааг илэрхийлсэн дүрслэх ур маягийг тодорхойлоорой.
“Ногоон халзан морины цагаан хөлхтэй зовхи
Нойтон байж билээ”
А. Тойруулал В. Төлөөлөл С. Хэтрүүлэл
D. Зүйрлэл E. Адилтгал
5. Дээрх эхээс зохиогчийн харуусан гэмшсэн үнэлэмжийг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
А. Буурал бүүвэйн эгшиг тасарч
Буруу хатавчинд өрхний оосор ээдрэв
В. Шүүрс алдам энэ дурдаггалын хуруудыг мэрэхэд
Шүд заншил хоёр эмтрэх шиг болдгийм
С. Дор хаяад
Долоон долоо дөчин есөн хоног боодог
D. Эрдэнийн ногоон халзан морины толгойг
Эгчийн алчуураар боолоо
E. Налж суудаг уул минь нурж
Намрын нуур ангираа гүвлээ
6. Дээрх эхийн сэдвийг тодорхойлоорой.
А. Эх үрийн элбэрэл хайрын тухай В. Намрын тухай
С. Хүний хувь заяаны тухай D. Монгол ёс заншлын тухай
E. Гэнэн хонгор хүүгийн тухай
7. Эхийн хэв маягийг олоорой.
А. Хүүрнэмж В. Тайлбарламж С. Эргэцүүлэмж
D. Тоочимж E. Учирламж
8. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
Эхийн сэдвийг үйл явдлаар дүрсэлж, дүгнэлт гаргахыг гэнэ.
А. Төрсөн санаа В. Гол санаа С. Шинэ санаа
D. Зорьсон санаа E. Төгс санаа
9. Эхийг уншаад “эмээ”-г тодотгон адилтгасан дүрслэл бүхий хэсгийг олоорой.
А. Ангир, эгшиг, оосор В. Уул, ангир, эгшиг С. Уул, нуур, эгшиг
D. Бүүвэй, хатавч, өрх E. Бүүвэй, эгшиг, оосор
10. Дараах өгүүлбэрийн утгын харьцааг тодорхойлоорой.
“Эмээ бурхан боллоо.
Налж суудаг уул минь нурж
Намрын нуур ангираа гүвлээ”
А. Зүйлчилсэн В. Төсөөт С. Эсрэг
D. Ойролцоо E. Ижил
11. Дараах өгүүлбэрийн баймж утгыг тодорхойлоорой.
“Шүд заншил хоёр эмтрэх шиг болдгийм”
А. Зайлшгүй баймж В. Бодит баймж С. Боллолцоот баймж
D. Хэм хэмжээт баймж E. Таамагласан баймж
12. Дараах өгүүлбэрийн шинжид тохирох тодорхойлолтыг олоорой.
“ Намрын нуур ангираа гүвлээ”
А. Энгийн, хүүрнэх, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
В. Энгийн, хүүрнэх, гурван бүрэлдэхүүнт, цөм бус өгүүлбэр
С. Энгийн, хүүрнэх, хоёр бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
D. Энгийн, хүүрнэх, хоёр бүрэлдэхүүнт, цөм бус өгүүлбэр
E. Энгийн, захирах, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
13. Дараах өгүүлбэрийн бүтцийг тодорхойлоорой.
“...Хуурын боолтыг унагахад нь
Ногоон халзан морины цагаан хөлхтэй зовхи
Нойтон байж билээ”
А. Цагийн байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
В. Орны байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
С. Болзлын байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
D. Шалтгааны байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
E. Өгүүлэгдэхүүн гишүүн өгүүлбэртэй харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр

14. Утгазүйжсэн холбоо үг бүхий хэсгийг олоорой.
 А. Ангираа гүвэх, буурал бүүвэй, эгчийн алчуур
 В. Хуурын боолт, буурал бүүвэй, хөлхтэй зовхи
 С. Энэ дурдатгал, өрхний оосор, манай говийнхон
 Д. Тэвхэн дээгүүр, тонгочиж бай-, эмтрэх шиг
 Е. Бурхан бол-, хоног хураа-, заншил эмтэр-
15. Дараах өгүүлбэрийн онцолсон үг ямар гишүүн болох вэ?
 “**Хоймроо** асан тонгочиж байгаад...”
 А. Өгүүлэгдэхүүн В. Өгүүлэхүүн С. Байц
 Д. Шууд тусагдахуун Е. Шууд бус тусагдахуун
16. Өгүүлбэрийн ямар хувиргал болохыг тодорхойлоорой.
 “Эмээ бурхан боллоо
 Буурал бүүвэйн эгшиг тасарч
 Буруу хагавчинд өрхний оосор ээдрэв”
 А. Хураах В. Салаалах С. Дэлгэрүүлэх
 Д. Тонгоргох Е. Ижилсүүлэх
17. Цэгийн оронд тохирох үгийг зөв дарааллаар байрлуулсан хэсгийг олоорой.
 “Алс ирээдүй юм
 Алхам бүр минь юм
 Алдаж онох минь юм
 Амьдрал гэдэг юм” /Х.Сампилдэндэв/
 А. Асуулт, хариулт, шалгалт, дүн В. Хариулт, шалгалт, асуулт, дүн
 С. Дүн, асуулт, хариулт, шалгалт Д. Шалгалт, дүн, хариулт, асуулт
 Е. Асуулт, хариулт, дүн, шалгалт
18. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
 А. Хүмүүний сэтгэлийг хөдөлгөн эс чадваас, хөнгөн бийрийг хөшиж юу хийнэ
 В. Цасан дээр мөртэй, цасан дээр нэртэй хүн шүү, би
 С. Бадам лянхуа цэцэг ч балчиг шавраас ургадаг
 Д. Эрх тэгш байхын анхдагч үзүүлэлт нь шударга ёс
 Е. Сэтгэл гэдэг бол хүний биед хоргодох нөмөр олсон бурхан юм
19. Онцолсон хэлц өгүүлбэрийг утгаар нь солин найруулбал аль нь тохирох вэ?
 “**Шүүрс алдам** энэ дурдатгалын хуруудыг мэрэхэд...”
 А. Санаа алдам В. Сэтгэл алдам С. Нүд алдам
 Д. Зүрх алдам Е. Хөл алдам
20. Дараах үгсийн аймгийг жишээтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
 1. Буурал, гэнэн, халуун, нойтон А. Төлөөлөх үгс
 2. Харуусал, тэвх, хурууд В. Тооны нэр
 3. Долоон долоо, хоёр, дөчин ес С. Жинхэнэ нэр
 4. Энэ, яагаа ч, миний Д. Тэмдэг нэр
 А. 1А, 2В, 3С, 4Е В. 1С, 2В, 3А, 4Д С. 1В, 2А, 3С, 4Д
 Д. 1С, 2А, 3В, 4Д Е. 1Д, 2С, 3В, 4А
21. Дараах хэлзүйн тайлбарт тохирох үгийг олоорой.
 /Ерийн, үүсмэл, ганц тоот, харьяалахын тийн ялгалд байгаа жинхэнэ нэр/
 А. Морины В. Дурдатгалын С. Эрдэнийн
 Д. Хорвоогийн Е. Хуурын
22. Дараах үгсийн утга, бүтцийг ажиглаад бусдаасаа өвөрмөц үгийг олоорой.
 А. Нуран В. Согтон С. Тэвхэн
 Д. Асан Е. Татан
23. Харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утгыг жишээтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
 1. Эзний А. Морины толгой
 2. Хамаарал харьяаны В. Намрын нуур
 3. Бүхэл хэсгийн С. Эгчийн алчуур
 4. Цаг хугацааны Д. Хуурын боолт
 А. 1Д, 2С, 3А, 4В В. 1В, 2С, 3А, 4Д С. 1А, 2В, 3С, 4Д
 Д. 1С, 2В, 3А, 4Д Е. 1В, 2А, 3Д, 4С
24. Дараах холбоо үгсийг ажиглаад, үндсэн (шууд) утгаараа байгаа үгийг олоорой.
 А. Ханын толгой В. Шүдэнзний толгой С. Сонины толгой

- D. Морины толгой E. Цагаан толгой
25. Дараах үгсэд бүгдэд нь тохирох дүрмийг тодорхойлоорой.
“Харуусал + ын, хоймор + оо, намар + ын”
A. Эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад төгсгөлийн балархай эгшиг гээгдэнэ
B. Эгшигт гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч эгшиггүй бичигдэнэ
C. Эгшигт гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл гээхгүй
D. Дараалсан хоёр заримдаг гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл эгшгийг гээхгүй
E. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад төгсгөлийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэнэ
26. Дараах үгсээс төрөл биш үгийг олоорой.
A. Сонин B. Сониуч C. Соньхон
D. Сонор E. Сонирхол
27. Дараах үгсээс хүндэтгэлийн үгс бүхий хэсгийг олоорой.
A. Гэр, овоохой, өргөө B. Занги, амбан, жасаа
C. Тунхуу, бураа, хараач D. Хөлийн цэц, тамгын газар, хоршоо
E. Ноёд, хагагтай, айлтгал
28. Дараах үгсийг утгатай нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
1. Шунгах шумбах, агшин эгшин A. Ойролцоо утгат үг
2. Малчин, дуучин, хилчин, зурагчин B. Төсөө утгат үг
3. Удаан түргэн, газар тэнгэр C. Эсрэг утгат үг
4. Зөрүүд, гөжүүд, адайр, этгээд D. Зүйлчилсэн утгат үг
A. 1A, 2B, 3C, 4D B. 1D, 2C, 3B, 4A C. 1D, 2A, 3C, 4B
D. 1C, 2A, 3B, 4D E. 1B, 2D, 3C, 4A
29. Дараах үгсээс дүрслэх язгуур бүхий хэсгийг олоорой.
A. Цөмлөх, нэвтрэх, задрах, бяцлах B. Тарих, давтах, хөдөлмөрлөх, үйлдэх
C. Суллах, нүдлэх, ганзагалах, хайрлах D. Хоржигнох, ганганах, тогших, цангинах
E. Жингэнэх, годгонох, хурхирах, сандрах
30. Дараах үгийг бүтцээр зөв задалсныг олоорой.
A. Ангир + 0 + 0 + аа B. Ангир + 0 + аа C. Анги + р + аа
D. Ангир + аа E. Ангир + аа + 0
31. Дараах агуулгын тайлбараас бурууг нь олоорой.
A. Ч.Лхамсүрэнгийн “Хурандаа” найраглалд ардын хувьсгалаар төрж, түүний батлан хамгаалах гавьяат замналтай амь амьдралаа холбосон эгэл жирийн эр цэргийн тухай өгүүлжээ.
B. Ц.Гайтавын “Дамдины Сүхбаатар” найраглалд монголын нийгэм дэх дарлагч, дарлагдагч хоёр ангийн зөрчил улам хурцдаж, ард түмний эсэргүүцэл улам гаарч, хуучин нийгмийг өөрчлөх түүхэн үед шилжсэнийг харуулжээ.
C. Б.Явуухулангийн “Сохор зоосны дууль”-д хөдөлмөрийн хүний хөлс хүч хоёрыг, хүн хүлэг болсон хөлсний тариачны амьдралыг эзэрхэг дэглэмийн дотроос сонгон дүрсэлжээ.
D. Д.Пүрэвдоржийн “Хөх даалимбан тэрлэг” найраглалд Халх голын дайн монгол нэгэн өрх гэрийн амьдралд ямар их хөнөөл, гамшиг учруулсныг харуулжээ.
E. Д.Пүрэвдоржийн “Сэгс цагаан богд” найраглал нь залуу насны хайр дурлалын сэдэвтэй бөгөөд хөдөөгийн нэгэн тосгонд хөгжмийн удирдаачаар ажилласан Замбага бүсгүйн хоёр жилийн амьдралыг харуулжээ.
32. Зохиолч ба зохиолын нэрийг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
1. Д.Намдаг A. Тунгалаг тамир
2. Б.Ринчен B. Их хувь заяа
3. С.Удвал C. Хувьсгал танаа өчье
4. Л.Түдэв D. Үүрийн туяа
5. Ч.Лодойдамба E. Цаг төрийн үймээн
A. 1A, 2B, 3C, 4D, 5E B. 1E, 2D, 3B, 4C, 5A C. 1D, 2C, 3E, 4B, 5A
D. 1B, 2A, 3E, 4D, 5C E. 1D, 2E, 3A, 4B, 5C
33. Дараах шүлгийн цэгийн оронд доорх өгөгдлөөс зөвийг сонгоно уу.
“Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө, би
Хөмсгөн сарны аялах алсын алс тойрогт
Холын хоёр одны тохиох бяцхан чөлөөнд
.....
Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө, би”

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Зохиолын нэр ба ишлэлийг зөв харгалзуулаарай.

- | | |
|----------------------|---|
| 1. Сэтгэлийг амраагч | A. "...Баясгалантай хөөрхөн царайг чинь хө
Бахархаад бахархаад баршгүй
Баярыг улам арвитгамаар хө..." |
| 2. Ичиг ичиг | B. "...Насны багад эрдэм сурахад
Залхуугүй бол даанч сайн..." |
| 3. Дөрвөн улирал | C. "...Аяа бас, төрийг цуугиулагч түшмэд ичиг
Аяа бас, номыг үл сурагч элдвийг сурагч банди нар ичиг..." |
| 4. Цаасан шувуу | D. "...Найман чөлөөт хүний биенийг олсноо
Насны идрийн цогоор нөгцөөв л..." |
| 5. Үлэмжийн чанар | E. "...Ачийн хариуг мэдэх хүн цөөн
Хилэнцийг мэдэвч хийх хүн олон..." |

2.2. Хэлцүүдийг эсрэг утгаар нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------------|----------------------|
| 1. Зүрх нь үх- | A. Ааг нь буцал- |
| 2. Хулхи нь буу- | B. Хөрөнгөндөө сага- |
| 3. Хөг нь өнгөр- | C. Ааг нь эрчил- |
| 4. Хоног төөрүүл- | D. Чихний чимэг бол- |
| 5. Чихний чийр бол- | E. Зориг нь бадар- |

2.3. Хэлц холбоо үгийн хэв шинжийг тохирох үгтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|----------|---------------------------------|
| 1. ХЗ+ХЗ | A. Монгол Улсын үндсэн хууль |
| 2. ҮС+ҮС | B. Энэ өдрийн амар амгалан |
| 3. ХЗ+УЗ | C. Мэдэхийн тулд судалж үзэх |
| 4. БЗ+ҮС | D. Алтан үеийнхний авьяас билэг |
| 5. УЗ+ҮС | E. Оддын дунд бодол бэлчих |

2.4. Найруулгын төрлийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------------------------|--|
| 1. Албан бичгийн найруулга | A. Мод шатаах, органик бодисын исэлдэлтээр 1.7 тэрбум тонн нүүрсхүчлийн хий ялгардаг. |
| 2. Эрдэм шинжилгээний найруулга | B. Эрүүл энх жаргаж яваарай
Их үйлсийг бүтээж яваарай |
| 3. Сонин нийтлэлийн найруулга | C. Төв талбайг та мэднэ тээ? Төв холбооны хажууханд. |
| 4. Уран зохиолын найруулга | D. Монгол Улсад эрдмийн зэргийг шинжлэх ухааны доктор, дэд доктор, эрдмийн цолыг профессор, дэд профессор байхаар тогтоосугай. |
| 5. Ярианы найруулга | E. Газрын харилцаа геодез зураг зүйн газраас аймгийн газрын албадад тоног төхөөрөмж өгөхөөр боллоо. |

ХУВИЛБАР С

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Хумсын чинээхэн нар

Өвөөгийн цээж давхаргагүй гэрт хүн ярих шиг дүнгэнэнэ. Хумсын чинээхэн нар тоононы дааганаас мултарч ядна. Өвөө тэр холоос сульдсан зүрхнээсээ дуугарна.

- Хүү адуугаа олоо болов уу? Адуу тургилахыг сонсох юмсан... гээд хэлсэн үгэндээ хахах мэт дуугүй болов.

Ашгүй уяан дээр дөрөө дуугарч, адуу гүнгэнэн үүрсэв. Өвөө бүтээсэн өрх шиг хүнд зовхио дааж ядан инээж,

- Хүү ирэв үү? Адуугаа олоо болов уу? гэх нь түрийчийнхээс тод дуудлав. Гарч хараагүй байж би,

- Тийм байна аа. Ах ирж байна. Адуугаа олчихож... гэж санаандгүй цээжний бангаар хэлчихлээ... Өвөө,-

Өө ашгүй дээ гээд гүнгэгий амьсгал татлаа... Сумын эмч орж ирүүтээ баруун хатавчинд цагаан нөмрөгөө өмсч гарлаа... Хумсын чинээхэн нар тоонон дааганаас нисэв.

(Б.Лхагвасүрэн)

1. Эхийн эхлэл, гол, төгсгөлийн тулгуур өгүүлбэр бүхий хэсгийг олоорой.
 - A. Өвөөгийн цээж давхаргагүй гэрт хүн ярих шиг дүнгэнэнэ.
Өвөө бүтээсэн өрх шиг хүнд зовхио дааж ядан инээж...
Сумын эмч орж ирүүтээ баруун хатавчинд цагаан нөмрөгөө өмсч гарлаа.
 - B. ...Дуугүй болов.
Адуугаа олчихож ... гэж санаандгүй цээжний бангаар хэлчихлээ...
Өө ашгүй дээ гээд гүнзгий амьсгал татлаа
 - C. Хумсын чинээхэн нар тоононы дааганаас мултарч ядна.
Ашгүй уяан дээр дөрөө дуугарч, адуу гүнгэнэн үүрсэв.
Хумсын чинээхэн нар тоонон дааганаас нисэв.
 - D. Хүү адуугаа олоо болов уу?
Хүү ирэв үү?
Тийм байна аа. Ах ирж байна.
 - E. Адуу тургилахыг сонсох юмсан ... гээд хэлсэн үгэндээ хахах мэт дуугүй болов.
Адуугаа олоо болов уу? гэх нь түрийчийнхээс тод дуулав.
Сумын эмч орж ирүүтээ баруун хатавчинд цагаан нөмрөгөө өмсч гарлаа.
2. Эхийн төрсөн санааг илэрхийлсэн тулгуур үгсийг олоорой.

A. Хүү, цээж, дөрөө	B. Өвөө, адуу, нар	C. Зовхи, амьсгал, нөмрөг
D. Хүү, ах, адуу	E. Өвөө, эмч, нар	
3. Эхийн гол санааг тодорхойлоорой.
 - A. Хүүхдийн гэнэн томоогүй, болчимгүй байдлыг харуулжээ
 - B. Хүний амьдралд жаргал зовлон ээлжилдэг
 - C. Төрсний эцэст үхнэ гэдэг хорвоогийн жам
 - D. Монгол хүн, адуу хоёрын холбоо бэлгэдлийг харуулжээ
 - E. Монгол хүний амьдралын хэв маягийг харуулжээ
4. Шинэ санааг илэрхийлсэн дүрслэх ур маягийг тодорхойлоорой. “хумсын чинээхэн, хэлсэн үгэндээ хахах мэт, давхаргагүй гэрт хүн ярих шиг, бүтээсэн өрх шиг”

A. Адилтгал	B. Хэтрүүлэл	C. Төлөөлөл	D. Зүйрлэл	E. Ихэсгэл
-------------	--------------	-------------	------------	------------
5. Зохиогчийн үнэлэмжийг илэрхийлсэн зорьсон санаа бүхий өгүүлбэрийг олоорой.
 - A. Мал адгуулах арга ухаан алдагдаж буйд харамссан
 - B. Монгол өвгөдийн хатамжит чанар, уужуу сэтгэл, зан төрхийг бахадсан
 - C. Залуу үеийнхнийг ухааруулан сургамжилсан
 - D. Амьдралын жамаар насан эцэслэж буй өвгөнийг өрөвдсөн
 - E. Төрсний эцэст үхэх хорвоогийн жамтай эвлэрсэн
6. Дээрх эхийн сэдвийг тодорхойлоорой.

A. Амьдралын жам ёсны тухай	B. Монгол төрх, монгол ахуйн тухай
C. Хүний хувь заяаны тухай	D. Адууны тухай
E. Хүүхдийн гэнэн хонгор зангийн тухай	
7. Эхийн хэв маягийг олоорой.

A. Хүүрнэмж	B. Тайлбарламж	C. Эргэцүүлэмж
D. Тоочимж	E. Учирламж	
8. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
“Зохиогчийн үзэл бодол, хүсэл санаа, сэтгэлийн хөдөлгөөн, өнгө аяс илэрснийг гэнэ.”

A. Төрсөн санаа	B. Гол санаа	C. Шинэ санаа
D. Зорьсон санаа	E. Төгс санаа	
9. Эхийг уншаад дараах дүрслэлийн учрыг тодорхойлоорой.
“Хумсын чинээхэн нар тоононы дааганаас мултарч ядна
Хумсын чинээхэн нар тоонон дааганаас нисэв”
 - A. Өвгөний бие доройтон байгааг нар тоонон дааганаас мултарч ядаж байгаатай, амьсгал хураах үеийг нар шингэх агшинтай адилтган дүрсэлжээ
 - B. Өвгөний бие доройтон байгааг нар тоонон дааганаас мултарч ядаж байгаатай, амьсгал хураах үеийг нар шингэх агшинтай зүйрлэн дүрсэлжээ
 - C. Өвгөний бие доройтон байгааг нар тоонон дааганаас мултарч ядаж байгаатай, амьсгал хураах үеийг нар шингэх агшинтай эсрэгцүүлэн дүрсэлжээ
 - D. Өвгөний бие доройтон байгааг нар тоонон дааганаас мултарч ядаж байгаатай, амьсгал хураах үеийг нар шингэх агшинтай харьцуулж, хэтрүүлэн дүрсэлжээ
 - E. Өвгөний бие доройтон байгааг нар тоонон дааганаас мултарч ядаж байгаатай, амьсгал хураах үеийг нар шингэх агшинтай адилтгаж, егөөдөн дүрсэлжээ

10. Дараах өгүүлбэрүүдийн утгын харьцааг тодорхойлоорой.
“Хумсын чинээхэн нар тоонон дааганаас мултарч ядна. Өвөө тэр холоос сульдсан зүрхнээсээ дуугарна”
А. Зүйлчилсэн В. Төсөөт С. Эсрэг
D. Ойролцоо E. Ижил
11. Дараах өгүүлбэрийн баймж утгыг тодорхойлоорой.
“Адуугаа олчхож гэж санаандгүй цээжний бангаар хэлчихлээ”
А. Зайлшгүй баймж В. Бодит баймж С. Үнэн магадлалт
D. Хэм хэмжээт баймж E. Боллоцот баймж
12. Дараах өгүүлбэрийн шинжид тохирох тодорхойлолтыг олоорой.
“Адуугаа олоо болов уу?”
А. Энгийн, анхааруулах, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
В. Энгийн, асуух, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
С. Энгийн, асуух, хоёр бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
D. Энгийн, хүүрнэх, хоёр бүрэлдэхүүнт, цөм бус өгүүлбэр
E. Энгийн, захирах, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
13. Дараах өгүүлбэрийн бүтцийг тодорхойлоорой.
“Адуу тургилахыг сонсох юмсан... гээд хэлсэн үгэндээ хахах мэт дуугүй болов”
А. Угсарсан нийлмэл өгүүлбэр
В. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
С. Холимог нийлмэл өгүүлбэр
D. Энгийн, нэрлэсэн өгүүлбэр
E. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
14. Нэрийн холбоо үг бүхий хэсгийг олоорой.
А. Өмсч гар-, сульдсан зүрх, хумсын чинээ
В. Мултарч яд-, тод дуулд-,гүнгэнэн үүрс-
С. Баруун хатавч, дөрөө дуугар-, бүтээсэн өрх
D. Хүнд зовхи, тоононы даага, амьсгал тат-
E. Хүнд зовхи, сумын эмч, цагаан нөмрөг
15. Дараах өгүүлбэрийн онцолсон үг ямар гишүүн болох вэ?
“Ашгүй уяан дээр **дөрөө** дуугарч, адуу гүнгэнэн үүрсэв”
А. Өгүүлэгдэхүүн В. Өгүүлэхүүн С. Шууд бус тусагдахуун
D. Шууд тусагдахуун E. Байц
16. Эхэд орсон дараах өгүүлбэр ямар хувиргалаар илэрснийг тодорхойлоорой.
“Тийм байна аа”
А. Хураах В. Дэлгэрүүлэх С. Салаалах
D. Тонгоргох E. Ижилсүүлэх
17. Цэгийн оронд тохирох үгийг зөв дарааллаар байрлуулсан хэсгийг олоорой.
“Түмэн жилийн нөөцтэй - Эх хэл минь
Түнэр харанхуйд зорчсон - Эх хэл минь
Болор хундаганд тольдсон - Эх хэл минь
Бороотой үдшийн тулганд ноцсон - Эх хэл минь” (О.Дашибалбар)
А. Оддын дагуул, түлээний чимээ, сарны дуулал, алтны уурхай
В. Сарны дуулал, түлээний чимээ, алтны уурхай, оддын дагуул
С. Алтны уурхай, оддын дагуул, сарны дуулал, түлээний чимээ
D. Түлээний чимээ, алтны уурхай, оддын дагуул, сарны дуулал
E. Оддын дагуул, сарны дуулал, алтны уурхай, түлээний чимээ
18. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
А. Үнэнийг хүндлэх нь төгс билгийн эх сурвалж
В. Тайхар чулуу тэнгэрээс ургаагүй, газраас унаагүй
С. Эрх тэгш байхын анхдагч үзүүлэлт нь шударга ёс
D. Үг нь үйл хэргийн сүүдэр
E. Зэр зэвсэг хангинаж байх цагт хууль ёс амаа хамхидаг
19. Онцолсон үгийг хэлцээр солин найруулбал аль нь тохирох вэ?
“Адуугаа олчхож ... гэж санаандгүй **цээжний бангаар** хэлчихлээ”
А. Цаасан малгай өмсүүл- В. Молиго үмхүүл- С. Улайм цайм
D. Ичих нүүргүй E. Цэнэггүй авах

20. Дараах тодруулсан үгсийг утгатай нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
- | | | |
|-------------------|--------------------|-------------------|
| 1. Холоос дуугар- | A. Үйл үг | |
| 2. Уяан дээр | B. Жинхэнэ нэр | |
| 3. Тоонон даага | C. Тэмдэг нэр | |
| 4. Дааж яд | D. Орон цагийн нэр | |
| A. 1C, 2D, 3B, 4A | B. 1C, 2B, 3A, 4D | C. 1B, 2A, 3C, 4D |
| D. 1D, 2C, 3B, 4A | E. 1B, 2C, 3A, 4D | |
21. Эхээс дараах хэлзүйн тайлбарт тохирох үгийг олоорой.
/Ерийн, үүсмэл, ганц тоот, заахын тийн ялгалд байгаа жинхэнэ нэр/
- | | | |
|---------------|------------|-----------|
| A. Адуугаа | B. Амьсгал | C. Зовхио |
| D. Тургилахыг | E. Хүү | |
22. Дараах үгсийн утга, бүтцийг ажиглаад, бусдаасаа өвөрмөц үгийг олоорой.
- | | | |
|----------|----------|----------|
| A. Дүгнэ | B. Хөгнө | C. Цэгнэ |
| D. Гагна | E. Шагна | |
23. Харьалахын тийн ялгалын нөхцөлийн утгыг жишээтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
- | | | |
|------------------------|-------------------|-------------------|
| 1. Бүхэл хэсгийн утга | A. Тоононы даага | |
| 2. Орны утга | B. Сумын эмч | |
| 3. Хамаа харьяаны утга | C. Уяан дээр | |
| 4. Харьцуулсан утга | D. Хумсын чинээ | |
| A. 1C, 2B, 3A, 4D | B. 1A, 2C, 3B, 4D | C. 1D, 2A, 3B, 4C |
| D. 1C, 2B, 3D, 4A | E. 1D, 2A, 3C, 4B | |
24. Дараах холбоо үгсийг ажиглаад, үндсэн (шууд) утгаараа байгаа үгийг олоорой.
- | | | |
|------------------|---------------|---------------|
| A. Өрх татах | B. Ус татах | C. Хань татах |
| D. Амьсгал татах | E. Уруу татах | |
25. Дараах үгсэд бүгдэд нь тохирох дүрмийг тодорхойлоорой.
“Хагавч, зүрх, мултарч, өмсч”
- | |
|--|
| A. Заримдаг гийгүүлэгч эгшигт гийгүүлэгчийн дараа өмнө хойноо эгшиггүй орж болно |
| B. Заримдаг гийгүүлэгчийн дотроос “с, х” үсгийн дараа “т, ч” үсэг өмнө хойноо эгшиггүй орж болно |
| C. Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч эгшигтэй бичигдэнэ |
| D. Дараалсан хоёр заримдаг гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл эгшигийг гээхгүй |
| E. Уламжлалын зарчим баримталж бичсэн үгийн эгшигийг гээхгүй |
26. Дараах үгсээс төрөл биш үгийг олоорой.
- | | | |
|------------|--------------|--------------|
| A. Цагаан | B. Цагаатгал | C. Цагаантан |
| D. Цагаагч | E. Цагариг | |
27. Дараах үгсээс хүндэтгэлийн үг бүхий хэсгийг олоорой.
- | | | |
|------------------------|------------------------|-----------------------|
| A. Зоог, магнай, өргөл | B. Жалавч, гишүү, гүүш | C. Жин, пун, цэн, лан |
| D. Хараач, хой, өөшхөө | E. Элэнц, хуланц, авга | |
28. Дараах үгсийг утгатай нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
- | | | |
|---------------------------------------|------------------------|-------------------|
| 1. Цагаа, цэгээ, арваганах, эрвэгэнэх | A. Ойролцоо утгат үг | |
| 2. Өвөө, хүү, ах, эмч | B. Төсөө утгат үг | |
| 3. Өрнө, дорно, тэгш, хазгай | C. Эсрэг утгат үг | |
| 4. Найз, нөхөр, анд, түнш | D. Зүйлчилсэн утгат үг | |
| A. 1A, 2B, 3C, 4D | B. 1D, 2C, 3B, 4A | C. 1D, 2A, 3C, 4B |
| D. 1C, 2A, 3B, 4D | E. 1B, 2D, 3C, 4A | |
29. Дараах үгсээс идэвхгүй язгуур бүхий хэсгийг олоорой.
- | | |
|--|--------------------------------------|
| A. Дүнгэнэнэ, мултарч, гүнгэнэн | B. Түлхүүр, дурсамж, эвхээс, ороолт |
| C. Суллах, онилох, ганзагалах, хайрлах | D. Өндөлзөх, онгичих, суух, ганганах |
| E. Гүнгий, давхаргагүй, хараагүй | |
30. Эхэд байгаа дараах үгийг бүтцээр зөв задалсныг олоорой.
- | | | |
|---------------------------|--------------------|---------------------|
| A. Нөмрөг + өө | B. Нөмөр + г + өө | C. Нөм + р + г + өө |
| D. Нөмөр + г + 0 + 0 + өө | E. Нөмрөг + 0 + өө | |
31. Дараах агуулгын тайлбараас бурууг нь олоорой.
- | |
|---|
| A. “Боржигоны бор тал” шүлэгт эх дэлхийгээс эх орноо, эх орноосоо төрсөн нутгаа тодруулж дүрслэхдээ төрсөн нутаг, эзэгнэсэн хүн хоёрын холбоог өвөрмөцөөр зураглан эзэн хүний сэтгэлийн бахдам шинжийг гаргажээ |
| B. ”Уянгын тойрог” шүлэгт анх хөлд орж буй хүү гэрийнхээ босгоор алхаж гэрээ нар зөв тойроод ирэх хугацаанд эцгийн нь дээлийг оёж суугаа эхийн сэтгэл хүүгээ гэсэн ганцхан бодлоор уяатайг уярам аястай дүрсэлжээ |

- С. “Мөнгөн хазаарын чимээ” шүлэгт хөдөө нутаг, малчин бүсгүйн хайрын сэтгэлийг дүрслэн гаргажээ.
 D. “Шоронгийн дуу” шүлэгт захиргаадалтын үеийн амьдрал, улс төрийн хилс хэлмэгдлийн үеийн үйл явдлыг дүрслэн үзүүлжээ
 E. “Өрнө дорно хоёр” шүлэгт дэлхий дахин, дайн ба энх тайван зэрэг олон эгзэгтэй асуудалд сэтгэл зовнин түгшиж буйг дүрслэн гаргажээ

32. Зохиолч ба зохиолын нэрийг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

- | | | |
|-----------------------|-----------------------|-----------------------|
| 1. М.Ядамсүрэн | A. Гологдсон хүүхэн | |
| 2. Д.Мягмар | B. Их тээлийн даваа | |
| 3. П.Пүрэвсүрэн | C. Залуу хос | |
| 4. Д.Гармаа | D. Тээрэмчин | |
| 5. Ц.Дамдинсүрэн | E. Халуун амьсгал | |
| A. 1A, 2B, 3C, 4D, 5E | B. 1C, 2D, 3B, 4E, 5A | C. 1D, 2C, 3E, 4B, 5A |
| D. 1B, 2A, 3E, 4D, 5C | E. 1D, 2E, 3A, 4B, 5C | |

33. Дараах шүлгийн цэгийн оронд доорх өгөгдлөөс зөвийг сонгоно уу.

“Хөх тэнгэрийн орныг эзэгнэнхэн төрлөө, би
 Хөх Монголын алдаршсаны үе дамжсан домогт
 Хүчирхэг дээдсийн нутагт мандсан хувьсгалын дөлөнд

Хөх тэнгэрийн орныг эзэгнэнхэн төрлөө, би”

- A. Хөмсгөн сарны аялах алсын алс тойрогт
 B. Холын хоёр одны тохиох бяцхан чөлөөнд
 C. Хөрст алтан дэлхийн үрчлээт магнай болсон
 D. Хоёр нүдний үзүүрт цэнхэрлэх төдий тэртээд
 E. Үйлдвэрийн өндөр яндангийн хэлэн улаан галанд

34. Зүй тогтлыг ажиглаад, цэгийн оронд тохирохыг олоорой.

“Тээрэмчин”, “Багш”, “Уянгын тойрог”, “Үер”

- | | | |
|-------------------|------------------|--------------|
| A. Ану хатан | B. Яг арван найм | C. Залуу нас |
| D. Халуун амьсгал | E. Их хувь заяа | |

35. Ц.Дамдинсүрэнгийн “Чемодантай юм” өгүүллэгийн Цэмаагийн дүрийн ямар шинжийг дараах зүйлстэй харьцуулан жишсэн бэ? Зөв хэсгийг олоорой.

- | | | |
|-----------------------|-----------------------|-----------------------|
| 1. Дотоод сэтгэл | A. Бумаатай | |
| 2. Хээнцэр байдал | B. Доголон өвгөнтэй | |
| 3. Хүн чанар | C. Хогийн савтай | |
| 4. Хувиа хичээсэн | D. Тогос шувуутай | |
| 5. Ичиж улайсан | E. Шаамарын алимтай | |
| A. 1C, 2D, 3A, 4B, 5E | B. 1E, 2C, 3D, 4B, 5A | C. 1B, 2D, 3A, 4C, 5E |
| D. 1A, 2B, 3C, 4D, 5E | E. 1D, 2A, 3C, 4E, 5B | |


36. Цэгийн оронд уран зохиолын төрөл зүйлүүдээс тохирохыг олоорой.

“Хүний амьдралын нэг л гол үйл явдлыг тухайн эгшинд нь дүрсэлж, түүгээрээ нийгмийн аль нэг чухал асуудлыг хөнддөг, хэмжээгээрээ туужаас бага туульсын төрлийн зохиолыг гэнэ”

- | | | |
|-------------|--------------|----------|
| A. Тууж | B. Найраглал | C. Роман |
| D. Өгүүллэг | E. Жүжиг | |


37. Бүх үг нь холбох эгшгийн дүрмээр бичигдсэн хэсгийг олоорой.

- A. B. C. D. E.



38. Дан зөөлөн дэвсгэрээр төгссөн үгтэй хэсгийг олоорой.






- A. B. C. D. E.



39. Дараах өгүүлбэрээс тодруулсан үгийг монгол бичгээр зөв бичсэнийг олоорой.
“Илбийн цэнхэр зэрэглээ нь номин”

- | | | | | |
|---|---|---|---|---|
| A. | B. | C. | D. | E. |
|  |  |  |  |  |

40. Дараах үгсийг утгатай нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой

- | | | | | |
|---|---|---|---|---|
| 1. | 2. | 3. | 4. | 5. |
|  |  |  |  |  |

a. Өвс хад-

b. Хэд хэчнээн

c. Хад жимс

d. Хэт цахиур

e. Хад чулуу

A. 1e, 2a, 3c, 4b, 5d

B. 1c, 2b, 3a, 4d, 5e

C. 1d, 2b, 3e, 4c, 5a

D. 1b, 2d, 3e, 4c, 5a

E. 1e, 2c, 3a, 4b, 5d

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Зохиолын нэр ба ишлэлийг зөв харгалзуулаарай.

- | | |
|----------------------|---|
| 1. Сэтгэлийг амраагч | A. “...Баясгалантай хөөрхөн царайг чинь хө
Бахархаад бахархаад баршгүй
Баярыг улам арвитгамаар хө...” |
| 2. Ичиг ичиг | B. “...Насны багад эрдэм сурахад
Залхуугүй бол даанч сайн...” |
| 3. Дөрвөн улирал | C. “...Аяа бас, төрийг цуугиулагч түшмэд ичиг
Аяа бас, номыг үл сурагч элдвийг сурагч банди нар ичиг...” |
| 4. Цаасан шувуу | D. “...Найман чөлөөт хүний биеийг олсноо
Насны идрийн цогоор нөгцөөв л...” |
| 5. Үлэмжийн чанар | E. “...Ачийн хариуг мэдэх хүн цөөн
Хилэнцийг мэдэвч хийх хүн олон...” |

2.2. Хэлцүүдийг эсрэг утгаар нь зөв харгалзуулаарай.

- | | |
|------------------------------|--|
| 1. Далан хэлтэй | A. Биеэ оторлох |
| 2. Давсанд явах | B. Цоожтой авдар |
| 3. Морь нохой мэт зүтгэх | C. Амаа үдүүлсэн юм шиг |
| 4. Үг илүүтийн эрүү хугархай | D. Үнэгний нүд залгих |
| 5. За гэвэл ёгүй | E. Нэг чихээрээ оруулаад нөгөө чихээрээ гаргах |

2.3. Хэлц холбоо үгийн хэв шинжийг тохирох үгтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|----------|-------------------------------------|
| 1. ХЗ+ХЗ | A. Улаанбаатар хотын засаг захиргаа |
| 2. ҮС+ҮС | B. Үнэний төлөө шударга байх |
| 3. ХЗ+УЗ | C. Эрх чөлөөний бэлгэ тэмдэг |
| 4. БЗ+ҮС | D. Алтан харацайн даль жигүүр |
| 5. УЗ+ҮС | E. Оддын дунд бодол бэлчих |

2.4. Найруулгын төрлийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------------------------|--|
| 1. Албан бичгийн найруулга | A. Мод шатаах, органик бодисын исэлдэлтээр 1.7 тэрбум тонн нүүрсхүчлийн хий ялгардаг. |
| 2. Эрдэм шинжилгээний найруулга | B. Эрүүл энх жаргаж яваарай
Их үйлсийг бүтээж яваарай |
| 3. Сонин нийтлэлийн найруулга | C. Төв талбайг та мэднэ тээ? Төв холбооны хажууханд |
| 4. Уран зохиолын найруулга | D. Монгол Улсад эрдмийн зэргийг шинжлэх ухааны доктор, дэд доктор, эрдмийн цолыг профессор, дэд профессор байхаар тогтоосугай. |
| 5. Ярианы найруулга | E. Газрын харилцаа геодез зураг зүйн газраас аймгийн газрын албадад тоног төхөөрөмж өгөхөөр боллоо. |

ХУВИЛБАР Е

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Алчуур зангидсан хуур

Өвөө өөд болоод сар гаруй боллоо. Гэрийн хоймор байдаг хуурны ногоон халзан морин толгойг эгчийн алчуураар боогоод бас л сар гаруй боллоо. Говьчуул хуурын нүдэнд гуниг унагахгүй гэж ингэж гашууддаг заншилтай. Долоон долоо дөчин ес хоног бооно.

Нэг өглөө зүүн хамар дээгүүр улаан тугтай машин гарч ирлээ. Манай гадаа тоосоор тургин зогсуут хэдэн хүн бууж ирлээ... Цай цүү болсноо дараа нь том сийрсэн малгайтай, нүдний тас хар шилтэй ах надад, - За хүү дэгдчих, Урлагийн бригад ирлээ гээд айл саахалтынхнаа хөөгөөд ир гэлээ... Орж ирснээсээ хойш туж л нүүр нүдээ будсан гоё эгч нөгөө сийрсэн малгайтай ахад хандаж, - Найруулагч аа, би ямар дуугаа дуулах юм бэ? гэж зузаан уруулаа бөмбөлзүүлэн дуугарав. Нөгөө өндөр ах,

- Өө ашгүй хууртай айл байна... гэснээ ухасхийн хоймор байсан хуурыг шүүрэн авах зуураа -Бас алчуур боочихсон нандин эд байхнээ... гээд алчуурыг хуу татахад, хуурын ногоон халзан морин толгойн том аягатай нүд дүүрэн нулимс нь эгшиж амжаагүй харагдав.

/Б.Лхагвасүрэн/

1. Эхийн эхлэл, гол, төгсгөлийн тулгуур өгүүлбэр бүхий хэсгийг олоорой.
 - А. Өвөө өөд болоод сар гаруй боллоо
Цай цүү болов
Өө ашгүй, хууртай айл байна
 - В. Говьчуул гашууддаг заншилтай
Долоон долоо дөчин ес хоног бооно
Нэг өглөө зүүн хамар дээгүүр улаан тугтай машин гарч ирлээ
 - С. ... Ногоон халзан морин толгойг эгчийн алчуураар боолоо
Манай гадаа тоосоор тургин зогсуут хэдэн хүн бууж ирлээ
... Айл саахалтынхнаа хөөгөөд ир гэлээ
 - Д. Говьчуул хуурын нүдэнд гуниг унагахгүй гэж ингэж гашууддаг заншилтай
Бас алчуур боочихсон нандин эд байхнээ... гээд алчуурыг хуу татав
... Хуурын ногоон халзан морин толгойн том аягатай нүд дүүрэн нулимс нь эгшиж амжаагүй харагдав
 - Е. Долоон долоо дөчин ес хоног бооно
... Найруулагч аа, би ямар дуугаа дуулах юм бэ?
... Хоймор байсан хуурыг шүүрэн авав
2. Эхийн төрсөн санааг илэрхийлсэн тулгуур үгсийг олоорой.
 - А. Алчуур, гуниг, хоног, сар, хоймор
 - В. Өвөө, хуур, заншил, найруулагч, нулимс
 - С. Машин, хүн, хуур, ах, заншил, алчуур
 - Д. Говьчуул, сар, хоног, ах, эгч, хүү
 - Е. Өвөө, алчуур, хүү, найруулагч, цай, айл
3. Эхийн гол санааг тодорхойлоорой.
 - А. Урлагийн хүмүүсийн амьдралын хэв маягийг харуулсан
 - В. Амьтай бүхэн бөхдөг хорвоогийн жамыг харуулсан
 - С. Миний өвөг дээдэстэй хамт ёс заншил минь үгүй болж байна
 - Д. Монгол хүний амьдралын хэв маягийг харуулсан
 - Е. Говьчуулын аж амьдралын тухай харуулсан
4. Шинэ санааг илэрхийлсэн дүрслэх ур маягийг тодорхойлоорой
“Хуурын ногоон халзан морин толгойн том аягатай нүд дүүрэн нулимс нь эгшиж амжаагүй харагдав”
 - А. Тойруулал
 - В. Төлөөлөл
 - С. Амьдчилал
 - Д. Багасгал
 - Е. Адилтгал
5. Зохиогчийн шүүмжлэлтэй хандсан өнгө аяс бүхий үнэлэмжийг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
 - А. Говьчуул хуурын нүдэнд гуниг унагахгүй гэж ингэж гашууддаг заншилтай.
 - В. Гоё эгч... зузаан уруулаа бөмбөлзүүлэн дуугарав.
 - С. За хүү дэгдчих, урлагийн бригад ирлээ гээд айл саахалтынхнаа хөөгөөд ир гэлээ.
 - Д. Өө ашгүй, хууртай айл байна ... гэснээ ухасхийн шүүрэн авах зуураа,... гээд алчуурыг нь хуу татахад, нүд дүүрэн нулимс нь эгшиж амжаагүй харагдав.
 - Е. Урлагийн бригад ирлээ гээд айл саахалтынхнаа хөөгөөд ир гэлээ...

6. Дээрх эхийн сэдвийг тодорхойлоорой.
 А. Говьчуулын тухай
 В. Амьдралын жам ёсны тухай
 С. Хүний хувь заяаны тухай
 Д. Монгол төрх, монгол ахуйн тухай
 Е. Монгол заншил, уламжлалын тухай
7. Эхийн хэв маягийг олоорой.
 А. Хүүрнэмж
 В. Тайлбарламж
 С. Эргэцүүлэмж
 Д. Тоочимж
 Е. Учирламж
8. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
 Сэдэв, гол санаа хоёрын нэгдэл болсон богино нэрлэлтийг гэнэ.
 А. Дүгнэлт
 В. Бүтэц
 С. Зохиомж
 Д. Өгүүлэгдэж буй юм
 Е. Гарчиг
9. Эхийг уншаад “найруулагч”-ийн дүрийг тодотгосон дүрслэл бүхий хэсгийг олоорой.
 А. Өндөр, малгайтай, гоё, нандин
 В. Дэгдчих, хөөгөөд ир, шүүрэн авах, хуу татах
 С. Том, аягатай, шилтэй, хууртай
 Д. Дүүрэн, ногоон, сийрсэн, өндөр
 Е. Хуу тат-, тас хар, халзан, зузаан
10. Дараах өгүүлбэрийн утгын харьцааг тодорхойлоорой.
 “Өвөө өөд болоод сар гаруй боллоо. Гэрийн хоймор байдаг хуурны ногоон халзан морин толгойг эгчийн алчуураар боогоод бас л сар гаруй боллоо”
 А. Зүйлчилсэн
 В. Төсөөт
 С. Эсрэг
 Д. Ойролцоо
 Е. Ижил
11. Дараах өгүүлбэрийн баймж утгыг тодорхойлоорой.
 “Говьчуул хуурын нүдэнд гуниг унагахгүй гэж ингэж гашууддаг заншилтай”
 А. Зайлшгүй баймж
 В. Бодит баймж
 С. Боллоцот баймж
 Д. Хэм хэмжээт баймж
 Е. Таамагласан баймж
12. Дараах өгүүлбэрийн шинжид тохирох тодорхойлолтыг олоорой.
 “Долоон долоо дөчин ес хоног болно”
 А. Энгийн, хүүрнэх, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
 В. Энгийн, хүүрнэх, гурван бүрэлдэхүүнт, цөм бус өгүүлбэр
 С. Энгийн, хүүрнэх, хоёр бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
 Д. Энгийн, хүүрнэх, хоёр бүрэлдэхүүнт, цөм бус өгүүлбэр
 Е. Энгийн, захирах, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
13. Дараах өгүүлбэрийн бүтцийг тодорхойлоорой.
 “Найруулагч аа, би ямар дуугаа дуулах юм бэ? гэж зузаан уруулаа бөмбөлзүүлэн дуугарав”
 А. Угсарсан нийлмэл өгүүлбэр
 В. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
 С. Холимог нийлмэл өгүүлбэр
 Д. Жинхэнэ нийлмэл өгүүлбэр
 Е. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
14. Бүхэлзүйжсэн холбоо үг бүхий хэсгийг олоорой.
 А. Тас хар, авах зуур, сар гаруй
 В. Гуниг унага-, өөд бол-, айл бай-
 С. Нэг өглөө, нөгөө ах, хэдэн хүн
 Д. Айл саахалт, цай цүү, ногоон халзан
 Е. Нүдний шил, хууртай айл, зузаан уруул
15. Дараах өгүүлбэрийн онцолсон үг ямар гишүүн болох вэ?
 “Манай гадаа **тоосоор** тургин зогсуут хэдэн хүн бууж ирлээ”
 А. Өгүүлэгдэхүүн
 В. Өгүүлэхүүн
 С. Байц
 Д. Шууд тусагдахуун
 Е. Шууд бус тусагдахуун
16. Эхэд орсон дараах өгүүлбэр ямар хувиргалаар илэрснийг тодорхойлоорой.
 “- Өө ашгүй, хууртай айл байна”
 А. Хураах
 В. Салаалах
 С. Дэлгэрүүлэх
 Д. Тонгоргох
 Е. Ижилсүүлэх
17. Цэгийн оронд тохирох үгийг зөв дарааллаар байрлуулсан хэсгийг олоорой.
 “...Хайраа илчилсэн минь- Эх хэл
 Хар нүдэнгээсээ сонссонминь- Эх хэл
 Хаана ч, хэзээ ч минь- Эх хэл
 Ханашгүй яруу минь -Эх хэл /О.Дашбалбар/
 А. Амин сүнс, шидэт эгшиг, ятга, ардын дуу
 В. Ятга, шидэт эгшиг, амин сүнс, ардын дуу
 С. Шидэт эгшиг, ардын дуу, амин сүнс, ятга
 Д. Ардын дуу, ятга, шидэт эгшиг, амин сүнс
 Е. Ятга, амин сүнс, ардын дуу, шидэт эгшиг

18. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
А. Амьдралын мөн чанар бол мөнхийн урсгал.
В. Хүн магтаалд боолгон, мартахуйд шингэдэг.
С. Хувь заяа оньсого мэт, нэр алдар хуурамч болой.
D. Марташгүй хань нөхөрт хагацашгүй муу үгийг бүү өгүүл.
E. Хүмүүс бие биенийхээ тулд л амьд явдаг.
19. Онцолсон хэлц өгүүлбэрийг утгаар нь солин найруулбал аль нь тохирох вэ?
“Говьчуул хуурын нүдэнд **гуниг унагахгүй** гэж ингэж гашууддаг заншилтай”
А. Цээж тэний- В. Хийморь доройт- С. Сүүдэр унага-
D. Урам хугар- E. Сэтгэлээр унага-
20. Дараах үгсийн аймгийг жишээтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
1. Нэг, дөчин ес, сар гаруй а. Төлөөлөх үгс
2. Би, ямар, хэдэн, нөгөө b. Тооны нэр
3. Гоё, нандин, улаан, дүүрэн c. Орон цагийн нэр
4. Зүүн, хойш, дээгүүр, d. Тэмдэг нэр
A. 1a, 2b, 3c, 4e B. 1c, 2b, 3a, 4d C. 1b, 2a, 3d, 4c
D. 1c, 2a, 3b, 4d E. 1d, 2c, 3b, 4a
21. Эхээс дараах хэлзүйн тайлбарт тохирох үгийг олоорой.
/Ерийн, үүсмэл, ганц тоот, заахын тийн ялгалд байгаа жинхэнэ нэр/
А. Гуниг В. Хоног С. Хуурыг D. Дуугаа E. Уруулаа
22. Дараах үгсийн утга, бүтцийг ажиглаад бусдаасаа өвөрмөц үгийг олоорой.
А. Байршил В. Заншил С. Түншил D. Ууршил E. Гаршил
23. Харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утгыг жишээтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
1. Орны а. Гэрийн хоймор
2. Зориулалтын b. Хуурын толгой
3. Бүхэл хэсгийн c. Эгчийн алчуур
4. Эзний d. Нүдний шил
A. 1d, 2c, 3a, 4b B. 1b, 2c, 3a, 4d C. 1a, 2d, 3b, 4c
D. 1c, 2d, 3a, 4b E. 1b, 2a, 3d, 4c
24. Дараах холбоо үгсийг ажиглаад, үндсэн (шууд) утгаараа байгаа үгийг олоорой.
А. Нүд алд- В. Нүд унага- С. Нүд хуур-
D. Нүд чил- E. Нүд булаа-
25. Дараах үгсэд бүгдэд нь тохирох дүрмийг тодорхойлоорой.
“Заншил, дөчин, эгшиж, дэгдчих”
А. Эгшигт гийгүүлэгч өмнөө буюу хойноо заавал эгшигтэй бичигдэнэ
В. Эгшигт гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч эгшиггүй бичигдэнэ
С. Эгшигт гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл гээхгүй
D. Дараалсан хоёр заримдаг гийгүүлэгч аль нэг талдаа эгшигтэй бичигдэнэ
E. Үгийн дунд орсон “ж, ч, ш”-ийн дараа “и” бичнэ
26. Дараах үгсээс төрөл биш үгийг олоорой.
А. Урлал В. Урла С. Урлаг
D. Урлаач E. Урлаа
27. Дараах үгсээс харь үг бүхий хэсгийг олоорой.
А. Машин, бригад, лүндэн В. Хөнөг, хой, ганжин
С. Рашаан, ус, шанд D. Хайрхан, урт хорхой, хээрийн амьтан
E. Нандин, сийрсэн, хамар
28. Дараах үгсийг утгатай нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
1. Цангах, ангах, агших, эгших а. Ойролцоо утгат үг
2. Өвөө, ах, эгч, хүү b. Төсөө утгат үг
3. Тус, ус, ач, бач c. Эсрэг утгат үг
4. Уужуу, аажуу, тайвуу d. Зүйлчилсэн утгат үг
A. 1a, 2b, 3c, 4d B. 1d, 2c, 3b, 4a C. 1d, 2a, 3c, 4b
D. 1c, 2a, 3b, 4d E. 1b, 2d, 3c, 4a
29. Дараах үгсээс үйл язгуур бүхий хэсгийг олоорой.
А. Гуниг, хоног, алчуур В. Зузаан, өндөр, ногоон
С. Нүдэнд, гашууддаг, хоног D. Боочихсон, амжаагүй, шилтэй
E. Найруулагч, саахалт, аягатай

30. Дараах үгийг бүтцээр зөв задалсныг олоорой.
- А. Бөм + бөлз + үүл + 0 + н
 В. Бөмбө + лз + үүл + н
 С. Бөм + бө + лз + үүл + н
 D. Бөмбөлз + үүл + н
 E. Бөмбө + лз + үүл + 0 + н
31. Дараах агуулгын тайлбараас бурууг нь олоорой.
- А. Ч.Лхамсүрэнгийн “Хурандаа” найраглалд ардын хувьсгалаар төрж, түүний батлан хамгаалах гавьяат замналтай амь амьдралаа холбосон эгэл жирийн эр цэргийн тухай өгүүлжээ
 В. Ц.Гайтавын “Дамдины Сүхбаатар” найраглалд монголын нийгэм дэх дарлагч, дарлагдагч хоёр ангийн зөрчил улам хурцдаж, ард түмний эсэргүүцэл улам гаарч, хуучин нийгмийг өөрчлөх түүхэн үед шилжсэнийг харуулжээ
 С. Б.Явуухулангийн “Сохор зоосны дууль”-д хөдөлмөрийн хүний хөлс хүч болон хүн хүлэг болсон хөлсний тариачны амьдралыг эзэрхэг дэглэмийн дотроос сонгон дүрсэлжээ
 D. Д.Пүрэвдоржийн “Хөх даалимбан тэрлэг” найраглалд Халх голын дайн монгол нэгэн өрх гэрийн амьдралд ямар их хөнөөл, гамшиг учруулсныг харуулжээ
 E. Д.Пүрэвдоржийн “Сэгс цагаан богд” найраглал нь залуу насны хайр дурлалын сэдэвтэй бөгөөд хөдөөгийн нэгэн тосгонд хөгжмийн удирдаачаар ажилласан Замбага бүсгүйн хоёр жилийн амьдралыг харуулжээ
32. Дараах зохиолын нэр ба дүрүүдийг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
- | | |
|------------------------|--|
| 1. Тунгалаг тамир | a. Данзан, Оюундарь, гүн Балданцэрэн |
| 2. Их хувь заяа | b. Хатанбаатар Магсаржав, Га гоён |
| 3. Хувьсгал танаа өчье | c. Дугаржав |
| 4. Үүрийн туяа | d. Ширчин, Батбаяр, Насанбат, Жамсранжав |
| 5. Цаг төрийн үймээн | e. Итгэлт, Төмөр, Эрдэнэ |
- А. 1a, 2b, 3c, 4d, 5e
 В. 1e, 2d, 3c, 4b, 5a
 D. 1b, 2a, 3e, 4d, 5c
 E. 1d, 2e, 3a, 4b, 5c
 C. 1e, 2b, 3c, 4d, 5a
33. Дараах шүлгийн цэгийн оронд доорх өгөгдлөөс зөвийг сонгоно уу.
 “Цаст цагаан уулыг эзэгнэнхэн төрлөө, би
 Цан хүүрэг савсаж, үүлс ороох оргилд
 Цасан ширхэг царцаж, мөс болох халилд

 Цаст цагаан уулыг эзэгнэнхэн төрлөө, би”
- А. Зуун түмэн үед монгол хүний идээшсэн
 В. Үлэг гүрвэлийн мөрийг өдий хүртэл хадгалсан
 С. Хөрст алтан дэлхийн үрчлээт магнай болсон
 D. Миний өвөг дээдсийн морин туурайд наалдсан
 E. Царгиа хүйтэн өвөл сарлагийн бух тошсон
34. Зүй тогтлыг ажиглаад цэгийн оронд тохирохыг олоорой.
 “Дамдины Сүхбаатар”, “Тээрэмчин”, “Хувьсгал танаа өчье”, “Хурандаа”
- | | | |
|--------------------------|-------------------|--------------|
| А. Учиртай гурван толгой | В. Тэхийн зогсоол | С. Залуу нас |
| D. Их тээлийн даваа | E. Их хувь заяа | |
35. Б.Лхагвасүрэнгийн “Боржигоны бор тал” шүлгийн дараах хэсгийг уран сайхны ямар аргаар дүрсэлсэн бэ?
 “Тэнгэр тийчиж намайг төрөхөд тал минь
 Торго шиг зөөлөн байсан
 Жаргал зовлон хоёрыг амсаж эдэлж
 Чулуун дээр чинь баяр гунигийн нулимс унагахад
 Эр хүн шиг нуруутай бай гэсэн шиг
 Эргүүлж над руу цацан хатуугаас хатуу байсан чи”
- | | | |
|-----------------|---------------|--------------|
| А. Хураангуйлал | В. Сөөлжүүлэл | С. Харшуулал |
| D. Бууруулал | E. Ахиулал | |
36. Цэгийн оронд уран зохиолын төрөл зүйлүүдээс тохирохыг олоорой.
 “Харилцан ярианы хэлбэрээр бичсэн, туульс болон уянгын зохиолын дүрслэх аргын боломжийг нэгтгэсэн шинжтэй бие даасан туульсын зохиолыг гэнэ”
- | | | | | |
|---------|--------------|----------|-------------|----------|
| А. Тууж | В. Найраглал | С. Роман | D. Өгүүллэг | E. Жүжиг |
|---------|--------------|----------|-------------|----------|
37. Бүх үг нь холбох эгшгийн дүрмээр бичигдсэн хэсгийг олоорой.
- | | | | | |
|--------|--------|--------|--------|--------|
| А. | В. | С. | D. | E. |
| ᠠᠨᠠᠭᠠᠨ | ᠠᠨᠠᠭᠠᠨ | ᠠᠨᠠᠭᠠᠨ | ᠠᠨᠠᠭᠠᠨ | ᠠᠨᠠᠭᠠᠨ |
| ᠠᠨᠠᠭᠠᠨ | ᠠᠨᠠᠭᠠᠨ | ᠠᠨᠠᠭᠠᠨ | ᠠᠨᠠᠭᠠᠨ | ᠠᠨᠠᠭᠠᠨ |

38. Дан зөөлөн дэвсгэрээр төгссөн үгтэй хэсгийг олоорой.

- | | | | | |
|----|----|----|----|----|
| A. | B. | C. | D. | E. |
| | | | | |

39. Дараах өгүүлбэрийн тодруулсан үгийг монгол бичгээр зөв бичсэнийг олоорой.
“Учран золгохын ерөөл оршиг”

- | | | | | |
|----|----|----|----|----|
| A. | B. | C. | D. | E. |
| | | | | |

40. Дараах үгсийг утгатай нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

- | | | | | |
|----|----|----|----|----|
| 1. | 2. | 3. | 4. | 5. |
| | | | | |

- | | | | | |
|-----------------------|-------------|-----------------------|---------------|-----------------------|
| a. Харь газар | b. Хар өнгө | c. Хар хар чимээ | d. Газар хар- | e. Нүдээр хар- |
| A. 1d, 2c, 3e, 4b, 5a | | B. 1c, 2b, 3e, 4d, 5a | | C. 1d, 2b, 3e, 4c, 5a |
| D. 1e, 2c, 3d, 4b, 5a | | E. 1e, 2d, 3a, 4c, 5b | | |

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Зохиолын нэр ба ишлэлийг зөв харгалзуулаарай

- | | |
|----------------------------------|--|
| 1. Алтан ордны үйсэн дээрх бичиг | A. “...Өргөж үл болох үүдтэй билээ.
Алхаж үл болох үүдтэй билээ...” |
| 2. Мандухай цэцэн хатны домог | B. “...Дөрвөн ойрад зарааны үс, хөрөөний шүд болж
Бат дөрвөлжин болж, байнга цуг байдаг...” |
| 3. Убаши хун тайжийн тууж | C. “...Хаан эзэндээ захирагдахад хүрвээс
Хаалга доор нь унаж өг...” |
| 4. Хув Нагваралын тууж | D. “...Халх онигудын газар хол болбоос бээр
Хайрлан санагалзахын агаар нэгэн буй...” |
| 5. Цогтын хадны бичиг | E. “...Цавьдар морь чинэгтэй, бор морь чимэгтэй
Өдөр балар, шөнө тодорхой...” |

2.2. Хэлцүүдийг эсрэг утгаар нь зөв харгалзуулаарай.

- | | |
|--------------------|----------------------|
| 1. Нүүр өгөх | A. Нүд булаах |
| 2. Хорголоо тоолох | B. Морьтой явах |
| 3. Сүлд нь тэнэх | C. Нүүр буруулах |
| 4. Нүд халтирах | D. Дүлий дүмбэ оргих |
| 5. Ам хуурайгүй | E. Гар султай |

2.3. Хэлц холбоо үгийн хэв шинжийг тохирох үгтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|----------|----------------------------|
| 1. ХЗ+ХЗ | A. Ард түмний эрх чөлөө |
| 2. ҮС+ҮС | B. Тэр жилийн ган гачиг |
| 3. ХЗ+УЗ | C. Байн байн дурсаж байх |
| 4. БЗ+ҮС | D. Алтан ургийн удам угсаа |
| 5. УЗ+ҮС | E. Сарны доор бодол хөврөх |

2.4. Найруулгын төрлийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------------------------|--|
| 1. Албан бичгийн найруулга | A. Хэл нь булчинлаг эрхтэн, хөндлөн судалт булчингаас
тогтоно. Хэлний гадна талаар салст бүрхэвч хучдаг. |
| 2. Эрдэм шинжилгээний найруулга | B. Ижий минь инээгээд над руу ирэхэд
Энэхэн замбуутивийн наран над дээр л асгардаг байсан. |
| 3. Сонин нийтлэлийн найруулга | C. Төв талбайг та мэднэ, тээ? Тэрний чинь тэрүүхэн |
| 4. Уран зохиолын найруулга | D. Монгол Улсын Их Хурлын тогтоол:Төрийн тусгай
хамгаалалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зарчим арга
хэмжээний тухай |
| 5. Ярианы найруулга | E. Монгол Улсын Засгийн газраас “Бүх нийтийн экологийн
боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. |

2009 оны Монгол хэлний хичээлийн даалгаврын түлхүүр

Нэгдүгээр хувилбар				
№	A хувилбар	C хувилбар	E хувилбар	G хувилбар
1	A	C	D	E
2	C	B	B	C
3	E	D	C	E
4	C	D	C	C
5	B	B	D	B
6	D	B	E	D
7	A	A	A	A
8	B	D	E	B
9	C	A	B	C
10	D	D	B	D
11	C	A	A	C
12	B	B	B	B
13	A	C	C	A
14	E	E	C	E
15	C	A	E	C
16	B	A	B	B
17	D	C	B	E
18	E	B	D	B
19	A	E	C	A
20	E	A	C	E
21	B	B	A	B
22	C	B	C	C
23	D	B	C	A
24	D	A	D	D
25	E	A	E	E
26	D	E	E	D
27	B	A	A	E
28	E	E	E	E
29	C	A	A	A
30	A	D	E	A
31	B	E	E	E
32	B	B	C	B
33	D	C	E	D
34	A	C	D	A
35	C	A	C	C
36	A	D	E	B
37	E	C	B	C
38	B	D	A	B
39	D	B	C	D
40	D	E	B	D

Хоёрдугаар хэсэг																
№	А хувилбар				С хувилбар				Е хувилбар				Г хувилбар			
	2.1	2.2	2.3	2.4	2.1	2.2	2.3	2.4	2.1	2.2	2.3	2.4	2.1	2.2	2.3	2.4
1	с	с	с	е	б	б	б	д	с	с	с	д	б	с	с	д
2	е	е	а	д	с	д	с	а	а	е	а	а	с	е	а	а
3	а	а	е	б	д	а	е	е	б	б	е	е	д	а	е	е
4	б	б	б	а	е	с	а	б	е	а	б	б	е	б	б	б
5	д	д	д	с	а	е	д	с	д	д	д	с	а	д	д	с